

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН АЗИ НОМХОН ДАЛАЙН
БҮСИЙН ЦАГ УУР/НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТ
СЭДЭВТ ЦАХИМ-ТЕЛЕ УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

2022.06.06

Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын (ICAO) Ази Номхон Далайн Бүсийн (APAC) Цаг Уур/Нислэгийн хөдөлгөөний менежмент (MET/ATM) цахим-теле уулзалтад ахлах синоптик инженер Э.Байгалмаа 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр оролцлоо.

Тус хурлын зорилго нь Ази, Номхон Далайн Бүсийн агаарын хөдөлгөөний менежментэд цаг уурын үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэх, нислэгийн хөдөлгөөний менежментийн шаардлагуудыг хангахад агаарын навигацийн цаг уурын үйлчилгээг цаашид хөгжүүлэх, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагаа, үр дүнгийн судалгаа, хийж хэрэгжүүлж байгаа ажлууд зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Тус уулзалтад Австрали, Бангладеш, Камбож, Канад, Хятад, Хонг Конг Хятад, Фижи, Энэтхэг, Индонез, Япон, Кирибати, Вьетнам, Бүгд Найрамдах Фижи Улс, Япон, Лаос, Малайз, Монгол, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Филиппин, БНАСАУ, Сингапур, Шри-Ланка, Тайланд, АНУ, Вануату зэрэг нийт 25 орон болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ICAO), Олон Улсын Агаарын Тээврийн Нисгэгчдийн холбоо (IFALPA)-ны гишүүд зэрэг нийт 194 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Уулзалтын чиглүүлэгчдээр Австралийн Цаг уурын албаны нисэхийн хэрэглэгчдийн ахлах Ашвин Найду, Вьетнамын ИН-ийн Агаарын навигацийн газрын дэд захирал Нигуан Лан Оах, Хонконгийн ажиглалтын төвийн шинжлэх ухааны ажилтан Люнь Ян Кристи, ОУИНБ-ын Ази Номхон далайн Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсийн ажилтан Хироюки Таката, ОУИНБ-ын Ази Номхон далайн Бүсийн Агаарын навигацийн цаг уур, орчны бүсийн ажилтан Петр Дунда нар ажиллалаа.

Хурлаар агаарын хөдөлгөөний үйлчилгээнд цаг уурын мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагаа, хамтын ажиллагааны дараах дүн шинжилгээ, судалгаа, сансрын цаг уурын зөвлөмжийн үйлчилгээ зэрэг сэдвээр 11 илтгэл тавигдсан.

Энэ уулзалтаас харахад, Монгол Улсын хувьд Агаарын хөдөлгөөн үйлчилгээний албанд Цаг уурын байгууллага цаг уурын үйлчилгээгээр хангасан байдал дээр дүн шинжилгээ хийх, цаг уурын үзэгдэл элемент, өгч буй зөвлөгөө, зөвлөмж дээр нарийвчилсан судалгааг улирал, хагас жил болон жилээр хийж дүгнэлт гаргах, судалгааны дүгнэлтээс цаашид авч хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөндөө тусгах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх зэрэг манай байгууллагын хувьд хэрэгтэй, ач холбогдолтой уулзалт байлаа.

Тайлан бичсэн:

Ахлах синоптик инженер



Э.Байгалмаа